

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2025/055/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Өмнөговь аймаг	Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
2025 он	Аудитын менежер: Т.Хонгорзул
	Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
	Ахлах аудитор: Б.Алтанцэцэг
	Утас: 8000-7121 Цахим хаяг: tolinetugen@gmail.com
	Толин этүгэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Б.Отгон-Өлзий
	Утас: 99844655 Цахим хаяг: otgon1118@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.21 № 37
танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БААСАНХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол, шинжлэх ухааны газар нь аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад сургалт, арга зүй, мэргэжил дээшлүүлэлт, мэргэжлийн тусалцаа үзүүлж, удирдлагаар ханган ажиллах, боловсролын байгууллагын удирдах ажилтан, уран бүтээлч, багш, иргэнд боловсрол мэргэжил эзэмших, мэргэжлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд нь туслах, чиглүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны А/1096 дугаар захирамжаар "Говийн оюу" хөгжлийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжих Өмнөговь аймгийн иргэдийн боловсролыг дэмжих зорилготой "Өмнөговь боловсрол" хөтөлбөрийг баталсан байна. Хөтөлбөрийн хүрээнд тайлант онд 900,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу санхүүжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.4 хувийн биелэлттэй байна.

4625020150

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг..

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБЯАР

2. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган

төгрөгөөр/ Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	10,329.9	39,025.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,245,565.9	6,665,761.9
Нийт хөрөнгийн дүн	5,255,895.8	6,704,787.3
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,255,895.8	6,704,787.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,255,895.8	6,704,787.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	3,557,712.5	8,651,578.3
Үйл ажиллагааны зардлын дүн	3,644,949.1	7,296,290.4
Үйл ажиллагааны үр дүн	(87,236.6)	1,355,287.9
Үйл ажиллагааны бус үр дүн	(3,925.9)	(33,696.4)
Үйл ажиллагааны нийт үр дүн	(91,162.5)	1,321,591.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,474,358.4	5,383,195.8
Тайлант оны үр дүн	(91,162.5)	1,321,591.5
Эцсийн үлдэгдэл	5,383,195.8	6,704,787.3
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,396,342.0	7,123,237.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,380,105.5	7,121,230.0
Үйл ажиллагааны ЦМГ	16,236.5	2,007.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(16,236.5)	-2,007.0
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	5,620,623.7	5,577,718.4
Урсгал зардал	5,620,623.7	5,577,718.4
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	5,620,623.7	5,577,718.4
Улсын төсвөөс санхүүжих	5,620,623.7	5,577,708.4
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос		10.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1													
	Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
1														
	Дүн												-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Дүн								